



**ХЭНТИЙ АЙМГИЙН
БАТШИРЭЭТ СУМЫН ХҮҮХДИЙН
ЦЭЦЭРЛЭГИЙН ЭРХЛЭГЧИЙН ТУШААЛ**

2025 оны 12 сарын 05 өдөр

Дугаар А/20

Батширээт сум

Хөрөнгө бүртгэж авах тухай

“Монгол улсын Боловсролын ерөнхий хууль”-ийн 33 дугаар зүйлийн 33.3.1, Сургуулийн өмнөх болон Ерөнхий боловсролын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.2, 28 дугаар зүйлийн 28.2.4 дэх заалт, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.1 дэх заалт, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн холбогдох заалт, Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2025 оны 12 дугаар сарын 04-ний өдрийн 05 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Тус байгууллагын 75 хүүхдийн барилга буюу хичээлийн 1 дүгээр байрын 408,494,279 (дөрвөн зуун найман сая дөрвөн зуун ерэн дөрвөн мянга хоёр зуун далан есөн) төгрөгийн өртөг бүхий их засварын үнийн дүнг тухайн барилгын үнийн дүнд нэмэгдүүлэн тооцсугай.

2. 75 хүүхдийн барилга буюу хичээлийн 1 дүгээр байрны нийт өртгийг 2025 оны 12 дугаар сараас нэмэгдүүлэн шинэчилсэн байдлаар үндсэн хөрөнгөд бүртгэсүгэй.

ЭРХЛЭГЧ



А.ХАНДЦОО